



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2022 он 06 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар Хэрг /1432

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
М.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Асуулгын хариуг хүргүүлэх тухай

Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Барилга, хот байгуулалтын яам болон нийслэлийн Засаг даргын Тамгын газраас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.


Хавсралт: 29 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000225007871





МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас: (976-11) 32-71-99, Факс: (976-11) 32-21-47
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2022.06.09 № 01/3058


танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн талаар асуулга тавьсантай холбогдуулан хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 17 хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР



111020000880

Монгол Улсын Засгийн газрын
Хэрэг эрхлэх газар

Бичиг хэрэг

Огноо *2022.06.10*

11 цаг *05* минут

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 09-ны өдрийн 01/308 дугаар
албан бичгийн хавсралт

Асуулга 1: 2020 оноос хойш зогсонги байдалд ороод буй гэр хорооллын дундын бүсүүдэд хэсэгчилсэн дэд бүтцийг холбох болон алслагдсан бүсүүдэд инженерийн дэд бүтэц бий болгох төслүүдийг Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах талаар болон эдгээр төслүүдийн санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна гадаадын зээл тусламжаар шийдэх боломжийн талаар:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөрт гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, газрыг дахин зохион байгуулах төслийг үргэлжлүүлэн, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангах ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд дундын бүсийн гэр хороололд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх дэд бүтцийн төв буюу “Сервис центр”-ийг ашиглалтад оруулах, захын бүсийн гэр хороололд бие даасан эх үүсвэр /сэргээгдэх эрчим хүч, цахилгаан, шингэрүүлсэн болон хийн түлш/ бүхий технологийг нэвтрүүлэх арга хэмжээг тусгасан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 118 дугаар тогтоолоор гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх “Дэд бүтцийн төв”-ийн төсөл хэрэгжүүлэх 16 байршлыг баталсан. “Дэд бүтцийн төв”-ийн төслийн хүрээнд улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт анхны жишиг “Дэд бүтцийн төв” төслийг 100 хувь хэрэгжүүлж дууссан. Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороо “Бичил дэд төв”-ийн 1 дүгээр багц ажил 100 хувь, хоёрдугаар багц ажлын дулааны шугам угсралтын ажлыг энэ онд багтаан хийж дуусгахаар ажиллаж байна. Налайх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Инженерийн дэд бүтцийн төсөл” 75 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороо, Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 23 дугаар хороонд хийгдэх “Дэд бүтцийн төв” төслийн зураг төслийн ажлын гүйцэтгэгчээр “Эм Эс Эл” ХХК ажиллаж байгаа бөгөөд ажлын явц 90 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 179 дүгээр тогтоолоор төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох бололцоогүй гэр хорооллын дундын болон захын бүсийн тодорхой байршлуудад бие даасан болон төвлөрсөн инженерийн дэд бүтэц бүхий нийт 50 бичил дэд төвийг барьж байгуулах төсөл, арга хэмжээг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 2.0 тэрбум юанийн будалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж, шаардагдах санхүүжилтийг 2017-2020 оны улсын төсөвт үе шаттайгаар тусган шийдвэрлэхийг Сангийн сайд, Гадаад харилцааны сайд, Барилга, хот байгуулалтын сайд нарт даалгасан.

Гэсэн хэдий ч тогтоолын хэрэгжилт удааширч, хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүйн улмаас “Дэд бүтцийн төв”-ийн бүтээн байгуулалтын ажил зогсонги байдалд орсон. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Дэд бүтцийн төв”-ийн төслийг

хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэхэд хүндрэлтэй тул цаашид улсын төсөвт хөрөнгө оруулалтын зардлыг үе шаттайгаар тусган шийдвэрлэх шаардлагатай байна.

Асуулга 2: Гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцжуулах ажлын хүрээнд удаашралтай байгаа төслүүдийн гүйцэтгэлийг сайжруулах чиглэлд төлөвлөсөн арга хэмжээнүүдийн талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 07/19, 12/43, 2014 оны 19/23, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 161, 2020 оны 48, 2021 оны 122 дугаар тогтоолуудаар гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийтдээ 28 байршил, 85 хэсэгчилсэн талбай батлагдсан. 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 18 байршлын 56 хэсэгчилсэн талбайд 43 төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 11,755 айлын орон сууцыг ашиглалтад оруулаад байна.

Дээрх 43 төсөл хэрэгжүүлэгчийн ажлын явц өнөөдрийн байдлаар:

- төсөл хэвийн үргэлжилж байгаа-18 төсөл хэрэгжүүлэгч,
- төслийн гүйцэтгэл удааширсан-17 төсөл хэрэгжүүлэгч,
- төслийн ажил дуусаж хүлээлгэн өгсөн-1 төсөл хэрэгжүүлэгч,
- шинээр төсөл хэрэгжүүлэх батламж авсан-16 аж ахуйн нэгж, байгууллага тус тус байна.

2015-2021 оны хооронд төслийн явц удаашралтай, гэрээний үүргээ биелүүлээгүй 26 /давхардсан тоогоор/ төсөл хэрэгжүүлэгчийн эрхийг цуцалсан.

Нийслэлийн 2022 оны төсөвт гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажилд 10.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр орчмын "В" хэсэгчилсэн талбайн гадна инженерийн шугам сүлжээний ажил,
- "Туул дэд станц", "Дүнжингарав" дэд станцаас Дэчинравжайлин хийдийн урд тал хүртэл цахилгаан хангамжийн шугам сүлжээний нэвтрэх сувгийн зураг төсөл, барилга угсралтын ажил (БЗД, 13, 14, 26 дугаар хороо),
- Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Орон сууцны 14 хороолол "А" хэсэгчилсэн талбайн цахилгааны 2*1000кВА хүчин чадалтай 5 ком ХТП-ийн зураг төсөл, барилга угсралтын ажил,
- 14 дүгээр хорооллын цахилгааны 110/35/10кв-ын дэд станцын гаргалгаа 4 иж бүрдэл, 10кв-ын хаалттай хуваарилах байгууламж 3 иж бүрдэл, 10кв-ын хаалттай дэд өртөө 12 иж бүрдэл, 10кв-ын 18.4км кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажлын үргэлжлэл,
- 14 дүгээр хороолол, "И" хэсэгчилсэн талбайн гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн дэд бүтцийн гадна цахилгаан хангамж, холбооны шугам сүлжээ (БЗД, 13 дугаар хороо),
- 14 дүгээр хороолол, "И" хэсэгчилсэн талбайн гэр хорооллын дахин төлөвлөлтийн борооны ус зайлуулах шугам сүлжээ (БЗД, 13 дугаар хороо),
- Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр орчмын "В" Хэсэгчилсэн талбайн гадна инженерийн шугам сүлжээний ажил,

- Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах "Түмэн Амгалан" орон сууцны хорооллын гадна инженерийн хангамжийн ажлын үргэлжлэл,
- Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороо гэр хорооллын дахин төлөвлөлтийн Б2 хэсэгчилсэн талбайн нэгдүгээр ээлжийн барилгажилтын төслийн инженерийн шугам сүлжээ,
- Бичил 7 дугаар хороолол орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн "Б" блокын гадна дулаан хангамжийн ажил (БГД, 11, 22 дугаар хороо),
- Сүхбаатар дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Орон сууцны VII хороолол орчмын "Б" хэсэгчилсэн талбайн УДДТ-ийн барилга, тоног төхөөрөмж, гадна дулааны шугамын ажил,
- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн "Эко яармаг-1" хорооллын гадна дулаан хангамж (ХУД, 4 дүгээр хороо).

Түүнчлэн Нийслэлээс Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээ, барилга угсралтын ажилд 32.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл, арга хэмжээний саналыг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.

Асуулга 3: Улаанбаатар хотын гэр хорооллын орчны болон хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн ажлууд, тэдгээрийн санхүүжилтийн хэрхэн шийдсэн талаар:

Орчны болон хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэвтрүүлэх, хүн ихээр зорчдог хотын гудамж талбай, автобусны эцсийн буудлууд дээр нийтийн бие засах газар байгуулах, нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах нийтээр дагах шийдвэр гаргах, хог хаягдлыг ангилан ялгах үйл ажиллагааг хэвшүүлж, ангилсан хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх, хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийн нөхцөлийг сайжруулж, олон жил хог дарж булсан ландфилын талбайг үе шаттайгаар хэсэгчлэн нөхөн сэргээлт хийх зэрэг ажлууд тусгагдсан.

Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

Шинжлэх Ухааны академийн Газарзүй геоэкологийн хүрээлэнтэй хамтран орчин үеийн судалгааны арга зүй, сансрын өндөр нарийвчлалтай зураг ашиглан нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 144,992 нүхэн жорлон тоологдсон. Нийслэл хотын хөрсний бүтэц онцлогт тулгуурлан нүхэн жорлонгоос үүдэх бохирдлыг 4 төвшинд бүсчлэн гаргасан.

Гандангийн дэнжийн хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр 640 өрхийн нүхэн жорлонд ариутгал халдваргүйтгэл, ашигтай бактери хийх ажлыг зохион байгуулсан. Тус ашигтай бактери /био задлагч/ нь хөрсний бохирдлыг арилгах, шээсний хүчлийг задлах, үнэр дарж, халдваргүйжүүлэхээс гадна хөрсний бордоо болох давуу талтай.

Улсын төсвийн 7,560.0 сая төгрөгийн хөрөнгөөр Туул голын хамгаалалтын бүсэд 4200 айл өрхийн нүхэн жорлонг шинэчлэх ажил хийгдэж байна. 2021 онд 2360 айл өрхийн нүхэн жорлонг шинэчилсэн. 2022 онд үлдсэн айл өрхийн нүхэн жорлонг

шинэчилж дуусгана. Мөн улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороонд “Хүн амын эрүүл мэндэд ээлтэй эко ариун цэврийн байгууламж байгуулах” 357 айл өрхийн нүхэн жорлонг шинэчлэх ажлын хүрээнд 160 айлын нүхэн жорлонг бүрэн шинэчилсэн. Уг ажил үргэлжилж байна.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайд нийтийн бие засах газар байгуулах ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо, Драгон төвийн зүүн талд, Хан-Уул дүүргийн ажилчны алдар талбайд тус тус нийтийн бие засах газрыг нийслэлийн төсвийн 215.5 сая төгрөгөөр байгуулсан. Мөн Туул голын эргийн дагуу 6 байршилд эко жорлонг нийслэлийн төсвийн 39.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгуулсан.

Ундны усны эх үүсвэр, ойн сан бүхий газрын орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд усан сан бүхий газар, ундны усны эх үүсвэрийн хориглолт, хязгаарлалтын бүсийн хилд өөрчлөлт оруулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ундны усны нөөц, эх үүсвэрийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах, усны эх үүсвэрүүдэд амьдарч буй гэр хорооллын өрхүүдийн жорлонг доторлуулах, угаадас нүхэн жорлонгийн стандартыг мөрдүүлж, бохир ус татан зайлуулах нэгдсэн системд холбох ажлыг зохион байгуулах, зайлшгүй газар чөлөөлөх шаардлагатай нэгж талбаруудын судалгааг гарган үе шаттай нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөн ажиллаж байна.

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт туул голын хойд эргийн дагуу нэр бүхий 19 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын эзэмшил газрууд нь ойн сан бүхий газрын хамгаалалтын бүс, усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсэд хамаарсан тул газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож нийтийн эдэлбэрт авсан.

Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаандаар хэлэлцүүлэн батлуулсан.

- Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Хөрөнгө гаргах тухай” А/1023 дугаар захирамжаар 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах, нийслэлийн гэр хорооллын айл өрхийн хэрэглээнд зориулан дүүрэг тус бүрт 10,000 тонноос доошгүй сайжруулсан түлшний нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

- 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхийг сайжруулсан түлшний 686 борлуулалтын цэгээр 253,928 тонн сайжруулсан түлшээр хангасан.

- Зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангах ажлын хүрээнд 6,098 өрхөд тус бүр 36 шуудай буюу нийт 219,528 шуудай сайжруулсан түлш олгож ажилласан.

- 2021 оны агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тооллогоор 3-15кВт хүртэл хүчин чадалтай 163,742 зуух, 15-100кВт хүртэл хүчин чадалтай 2,469 зуух, 100-420кВт хүртэлх хүчин чадалтай 410 усан халаалтын зуух, 4200кВт-аас дээш хүчин чадалтай 41 зуух бүртгэгдсэн байна. Мөн хөдөлгөөнт эх үүсвэр буюу 661,348 авто тээврийн хэрэгсэл тоологдсон байна.

- Түүхий нүүрсний хэрэглээг бууруулах зорилгоор 4 байршлын 36 халаалтын зуухыг буулган, төвлөрсөн дулаанд холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Асуулга 4: 2013 оноос хойш гүйцэтгэл нь удааширсан гэр хорооллын дахин төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлууд, тэдгээрийг түргэвчлэх чиглэлд авч буй арга хэмжээний талаар. Тухайлбал, 2013 онд эхлүүлсэн Чингэлтэй дүүргийн 14, 15 дугаар хорооны 72 дугаар сургуулийн орчим, 2014 онд эхлүүлсэн 9, 10, 11 дүгээр хороо Дэнжийн мянга орчим А хэсэгчилсэн талбай орчмын төслүүд одоо хүртэл ашиглалтад ороогүй байна. Эдгээр ажлуудыг хурдавчилж, төслийг үр дүнтэй гүйцэтгэж дуусгах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар:

Чингэлтэй дүүргийн 13, 15 дугаар хороо, 72 дугаар сургууль орчимд “Асар Өргөө” ХХК, “Буурал сутай” ХХК-иуд Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/538 дугаар захирамжаар төсөл хэрэгжүүлэгчээр батламжлагдсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд “Асар Өргөө” ХХК нь 100 айлыг орон сууцжуулахаар төлөвлөснөөс 2021 онд 20 айлын орон сууцыг ашиглалтад оруулж газар чөлөөлөлт хийсэн 9 нэгж, талбарын өрхүүдийн асуудлыг шийдвэрлэж, орон сууцанд оруулсан. “Буурал сутай” ХХК нь 126 айлыг орон сууцжуулахаар төлөвлөснөөс 48 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан. Газар чөлөөлөлт хийсэн 14 нэгж талбарын айл өрхийг орон сууцанд бүрэн оруулсан. Тус байршилд нийслэлийн 4,501.3 сая төгрөгийн төсвөөр хийгдэж буй инженерийн шугам сүлжээний ажлын хэрэгжилт 75 хувийн гүйцэтгэлтэй байна.

Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн мянга орчим А хэсэгчилсэн талбайд нийслэлийн 7,837.7 сая төгрөгийн төсвөөр хийгдэж буй инженерийн шугам сүлжээний ажлын хэрэгжилт 89 хувьтай байна. Тухайн хэсэгчилсэн талбайд Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/466 дугаар захирамжаар “Бармон” ХХК төсөл хэрэгжүүлдэг бөгөөд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөөр 3,741 айлыг орон сууцжуулахаар төлөвлөснөөс 2019 онд 234 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, газраа чөлөөлсөн 106 нэгж талбарын өрхийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. 2022 онд 234 айлын орон сууцыг ашиглалтад оруулахаар төлөвлөн, төслийн ажил хэвийн явагдаж байна.

Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 орчмын “Б”, Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 орчмын “В”, Чингэлтэй дүүргийн 7, 8 дугаар хороо МҮОНРТ орчмын талбайн нэгж талбарыг жижиглэн хувааж, дахин сонгон шалгаруулалт явуулахаар ажлын даалгаврыг шинэчлэх ажил хийгдэж байна.

Чингэлтэй дүүргийн 7, 8 дугаар хороо, Баянгол дүүргийн 11 дүгээр хороо МҮОНРТ орчим болон Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 орчмын талбайд төсөл хэрэгжүүлэгч “Эрэл” ХХК-ийн эрхийг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/268, А/269 дүгээр захирамжаар цуцалсан бөгөөд одоогоор шүүхийн маргаантай байна. Шүүхийн маргаан эцэслэгдэн шийдвэрлэгдсэний дараа сонгон шалгаруулалтыг зарлахаар төлөвлөсөн.

Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 орчмын “В” хэсэгчилсэн талбайд 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр төсөл сонгон шалгаруулалт зарлаж, “Рино инженеринг” ХХК нь үнэлгээний хорооны дүгнэлтээр төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан боловч тус байршилд Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр болон Чингэлтэй дүүргийн 8, 9 дүгээр хороодын нутаг дэвсгэрт дамнан байрших цэвэр усны хамгаалалтын бүс байгуулагдахаар төлөвлөсөн байсан тул тухайн компани төсөл хэрэгжүүлэх ажлыг явуулахаас

татгалзсан. Иймд төлөвлөгдсөн газруудыг байршлаас хасаж, хэсэгчилсэн талбайд дахин ерөнхий төлөвлөгөө батлуулахаар ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/962 захирамжаар Чингэлтэй 7, 8 дугаар хороо, МҮОНРТ орчмын талбайд “Басмаа” ХХК шалгарсан боловч 2018 оны А/434 дугаар захирамжаар төслийг цуцалсан. Тус компаниас үүсгэсэн шүүхийн маргаан шийдвэрлэгдсэн тул төсөл хэрэгжүүлэгчийг дахин сонгон шалгаруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Нийслэлийн зүгээс 2025 он гэхэд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслөөр нийт 20,000 айлын орон сууцыг ашиглалтад оруулах зорилт тавин ажиллаж байгаа болно.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Г "Дэд бүтцийн төв" төслийг хэрэгжүүлэх
байршлууд батлах тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 84 дүгээр тушаалаар баталсан "Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам"-ын 2.2-т заасныг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх "Дэд бүтцийн төв"-ийн төсөл хэрэгжүүлэх байршлуудыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан байршлуудад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг боловсруулах, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх төсөл, төсөв, техникийн шийдлийг эцэслэн боловсруулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралд 2018 оны 08 сарын 01-ний дотор танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /С.Батболд/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай

ДАРГА



С.АМАРСАЙХАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэгүүлэгчдийн 2018 оны 07 дугаар сарын
09-ний өдрийн 12 дугаар тогтролын хавсралт



“ДЭД БҮТЦИЙН ТӨВ” ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙРШИЛ

№	Дүүрэг	Хороо	Талбайн хэмжээ /га/
1	Сонгинохайрхан	1	18
2	Сонгинохайрхан	2	15
3	Сонгинохайрхан	4	17
4	Сонгинохайрхан	10	13
5	Баянгол	23	14
6	Сүхбаатар	18	18
7	Баянзүрх	19	12
8	Баянзүрх	23	14
9	Баянзүрх	28	17
10	Хан-Уул	9	15
11	Налайх	1	20
12	Багануур	5	16
13	Багахангай	2	11
14	Чингэлтэй	16	12
15	Чингэлтэй	17	15
16	Чингэлтэй	7	14



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 6 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар
хот


Улаанбаатар хотын гэр хорооллын дахин
төлөвлөлтийн төслийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 7.1.1, 7.1.2-т заасныг
үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд
хэрэгжүүлэх инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий бичил дэд төвүүд
байгуулах төсөл болон инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний ажлын
жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий бичил дэд төвүүдийн зураг
төслийг хот төлөвлөлтийн болон барилгын норм, нормативын баримт бичгийн
шаардлагад нийцүүлэн боловсруулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар
хангаж, хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах арга
хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт даалгасугай.

3. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төсөл, арга хэмжээг Бүгд
Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох
2.0 тэрбум юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж, шаардагдах
санхүүжилтийг 2017-2020 оны улсын төсөвт үе шаттайгаар тусган шийдвэрлэхийг
Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Барилга,
хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр нарт тус тус даалгасугай.




Ж.ЭРДЭНЭБАТ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Г.МӨНХБАЯР

Засгийн газрын 2017 оны 179 дүгээр
тогтоолын хавсралт



Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хэрэгжүүлэх инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий бичил дэд төвүүд байгуулах төсөл, инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний өргөтгөлийн ажлын жагсаалт (2017-2020)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага, хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Гүйцэтгэх ажлын байршил, тоо хэмжээ, хүчин чадал
1		Инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий бичил дэд төв буюу сервис центр	Баянгол дүүргийн 9, 21, 23 дугаар хороонд бичил дэд төвүүдийг барих;
2	Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох боллоцгоогүй гэр хорооллын дундын болон захын бүсийн тодорхой байршлуудад бие даасан болон төвлөрсөн инженерийн дэд бүтэц бүхий нийт 50 бичил дэд төвийг барьж байгуулах төсөл	Барилга, хот байгуулалтын яам	Баянзүрх дүүргийн 2, 4, 5, 9, 17, 19, 20, 21, 22, 23, 24, 27, 28 дугаар хороонд бичил дэд төвүүдийг барих; Сонгинохайрхан дүүргийн 2, 4, 5, 7, 8, 11, 25, 28 дугаар хороонд бичил дэд төвүүдийг барих; Чингэлтэй дүүргийн 9, 10, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19 дугаар хороонд бичил дэд төвүүдийг барих; Хан-уул дүүргийн 16 дугаар хороонд бичил дэд төвүүдийг барих; Сүхбаатар дүүргийн 12, 13, 14, 16, 17, 18, 19 дугаар хороонд бичил дэд төвүүдийг барих.
II. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлууд			
1	Усан сан өргөтгөх төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Баянзүрх дүүрэгт байрлах Зүүн хойд бүсийн одоо байгаа 6000м ³ усан сан дээр нэмж W=4х6000м ³ =24000м ³ -аар өргөтгөн нийт 30000м ³ болгох барилга угсралтын ажил;
2	Гэр хорооллын суурьшлын бүсэд усан сан, насос станц, шугам сүлжээ барих төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Баянзүрх дүүрэгт байрлах Хужирбуланд 2х500м ³ , Цайз орчимд 2х1000м ³ , Чингэлтэй дүүрэгт байрлах Салхит (Шадивлан) орчимд 2х500м ³ , Сонгинохайрхан дүүргийн Баруун салаа 2х1000м ³ , Зүүн салаа 2х500м ³ , Толголт 2х500м ³ , Тахилт 2х500м ³ .

-3-
20

3	Туул-1 коллектор төслийн 3, 4 дүгээр ээлжийн барилга угсралтын ажил	Барилга, хот байгуулалтын яам/ Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Хан-Уул дүүргийн Зайсан орчимд 2х500м ² , Баянгол, Сонгинохайрхан дүүргийг дамжих ф1200-ф1500 мм-ийн голчтой 10580 м шугамын барилга угсралтын ажил (Нийт трассын дагуух 232 аж ахуйн нэгжийн газар чөлөөлөлтийн зардал тусгагдаагүй болно);
4	Гэмтлийн эмнэлэгийн баруун талаар Ард Аюушийн өргөн чөлөөний дагуу ариутгах татуургын коллектор шугамын барилга угсралтын ажил	Барилга, хот байгуулалтын яам/ Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Баянгол дүүргийн Бичил Үл хорооллын ХЕТ-ний дагуу ф400-ф600 мм-ийн 2200 м шугамын барилга угсралтын ажил;
5	Нэгдүгээр хорооллын хойд хэсгийн ариутгах татуургын коллектор шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Барилга, хот байгуулалтын яам/ Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Сонгинохайрхан дүүргийн Нэгдүгээр хорооллын хойд талын зам дагуу 32-р байрны баруун урд төв коллектор хүртэл ф500 мм-ийн голчтой 2000 м шугам барих;
6	Ариутгах татуургын 12а, 12б коллекторын өргөтгөл шинэчлэлийн ажил	Барилга, хот байгуулалтын яам/ Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Баянзүрх дүүргийн 3, 4, 7 дугаар хороо Сансрын тунеллээс зүүн 4 замын уулзвар хүртэл ф200мм-ийн голчтой шугамыг ф500 мм болгон өргөтгөх;
7	Бохир усны 16-р хорооллын салбар шугам өргөтгөн шинэчлэх зураг төсөл барилга угсралтын ажил	Барилга, хот байгуулалтын яам/ Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Баянзүрх дүүргийн 16-р хорооллын хойно Хөргөлт сервис ХХК-ийн баруун талаас Саруул тэнгэр цогцолбор хүртэл Да хүрээний гудамж дагуу ф200мм-ийн голчтой 1100 м шугамыг ф400 мм болгон өргөтгөн шинэчлэх;
8	Цайз ариутгах татуургын ф400мм коллектор шугамын барилга угсралтын ажил	Барилга, хот байгуулалтын яам/ Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Баянзүрх дүүргийн 5, 19, 22 дугаар хороо, Цайз зах орчим, Доржийн гудамж дагуу болон Дандарбаатарын гудамж дагуу ф400мм-ийн голчтой 1750 м шугамын барилга угсралтын ажил;
9	Гэр хорооллын суурьшилын бүсэд ариутгах татуургын гол шугам сүлжээ барих төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Баянзүрх дүүргийн Хужирбулан, Улиастай, Цайз зах орчимд; Сүхбаатар дүүргийн Дамбадаржаа орчимд; Чингэлтэй дүүргийн Салхит орчимд; Сонгинохайрхан дүүргийн Баруун салаа, Зүүн салаа, Төлгойт орчимд;
10	Шинэ яармаг хорооллын ариутгах татуургын гол шугам сүлжээ, насос станц барих төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 8, дугаар хороо Яармагийн гэр хороолол, 1ш насос станц, ф400/500 мм-ийн голч бүхий шугамын зураг төсөл угсралтын ажил, Шинэ яармаг хороололд ф600 мм-ийн голч бүхий 3390 м шугамын угсралтын ажил 8 Шинэ яармаг хороололд 1ш насос станц.

III. Дулаан хангамжийн барилга, байгууламж, шугам сүлжээний ажлууд		
1	Шинэ яармаг хорооллын дулаан хангамжийн шугам сүлжээ, насос станц барих төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК
2	Толгойт орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбох төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК
3	Амгалан дулааны станцын үр ашгийг дээшлүүлэх, Доржийн гудамж, Маахуур толгой, Цайз, Да хүрээ зах орчмыг төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбох төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК
4		
5		
6	Амгалан дулааны станцын үр ашгийг дээшлүүлэх, Гачууртын гудамж, орчмыг төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбох төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК
7	Сэлбэ дэд төв, Дарь-Эх нэгж хороолол, 9 нэгж хорооллыг төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбох төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК
8	Нэгдүгээр хорооллын хойд хэсэг, Бичил Үш хороолол орчмыг төвлөрсөн хангамжийн сүлжээнд холбох төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК
9	Да хүрээ орчмын дулаан хангамжийн дэд бүтцийн төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК

Хан-Уул дүүргийн 5, 6, 7, 8 дугаар хороо, Нисэх Яармагийн орчимд, Туул гол дээгүүр ДЦС-4-өөс гарсан ф600 мм-ийн голчтой шугамыг үргэлжлүүлэх 2Ду600/500/400-ийн урттай төв магистрал шугам, дайжуулах сүлжээний ф300мм L=3.1км, ф250мм L=3.0км, ф200мм L=3.77км, ф150мм L=9.2км шугам, Ус дулаан дамжуулах төвийн барилга 42 ширхэг;

Сонгинохайрхан дүүргийн 4, 20, 27 дугаар хороо, 9в магистралын 48-р цэгээс Толгойтын гудамж дагуулан Баянхошууны гудамж хүртэл 2Ду500 мм-ийн голчтой 4 км дулааны шугам татах;

Баянзүрх дүүргийн 16, 22 дугаар хороо БХИС-ийн зүүн талаар Нянтайсүрэнгийн гудамжаар Да хүрээгийн гудамж хүртэл 2Ду600 мм-ийн голчтой дулааны шугам татах;

Баянзүрх дүүргийн 4, 5, 19, 22 дугаар хороо, Нянтайсүрэнгийн гудамжнаас Да хүрээгийн гудамж, Доржийн гудамж дагуу ф400/300/200мм-ийн голчтой 4.3 км дулааны шугам татах;

Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хороо 12г, Д магистраль буюу УС-15-ийн ЦТП-ээс БХЯ хүртэлх одоо байгаа 2Д500 мм-ийн шугамыг 2Ду700 мм болгож өргөтгөх;

Баянзүрх дүүргийн 10, 12 дугаар хороо Цагдаагийн академийн өргөн чөлөөнөөс Гачууртын гудамж болон БЗД-ийн 12 дугаар хороонд 2.5 км дулааны шугам 3 ширхэг Ус дулаан хуваарилах төв барих;

Амгалан дулааны станцаас бд магистралтай холбогдох ф800 мм-ийн шугам, бд магистралаас сэлбэ дэд төв хүртэлх ф700/ф500 мм-ийн голчтой нийт 7.2 км шугам, 2500т/ц хүчин чадалтай насос станц (Амгалан Дулааны станцын өргөтгөл);

Сонгинохайрхан дүүргийн 12-17, 30, 31 дүгээр хороо, Баянгол дүүргийн 9, 10, 11, 21, 22 дугаар хороо У-18 дугаар цэгээс 1 дүгээр хорооллын хойд талын зам, гэмтлийн эмнэлгийн зам, 3 дугаар хорооллын арын зам дагуу ф400/500мм-ийн голчтой 4000 м дулааны шугам шинээр барих (Өнөр хорооллын гудамж, Ард Аюушийн өргөн чөлөө, Хасбаатарын гудамж дагуу);

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд Баянзүрх дүүргийн 17 дугаар хороо Да хүрээ орчмын дулаан хангамжийн дэд бүтцийн ажил гүйцэтгэх.

3	<p>ажлыг эрчимжүүлэх төсөл</p> <p>Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хороо, Орон сууцны 14 хороолол И хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл</p>	<p>Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар</p>	<p>9540м; Холбоо: 2-4 яндантай сувагчлал, 910 м; Дулаан хангамж: Ус, дулаан дамжуулах төв-3ш, Ø159мм- Ø379 мм шугам-734 м; Ус хангамж: Ø90- Ø160 мм шугам-216 м; Цахилгаан хангамж РП-1ширхэг, ХТП-3 ширхэг, 10кВ-ын кабель 1500 м; Холбоо: Сувагчлал Ø110х6-460 м; Дулаан хангамж: 12.3 Мвт-ын халаалтын зуух-1, Ус, дулаан дамжуулах төв-1ш, Ø70-Ф300 мм шугам-758 м; Ус хангамж: Ø110-280мм шугам-864 м; Ариутгах татуурга: Ø200-300мм шугам-976 м, Ø500-543 м; Цахилгаан хангамж: РП-1, ХТП-10 ширхэг, 10кВ-ын кабель 6000 м; Холбоо: 6 яндантай сувагчлал, 800м; Дулаан хангамж: Ус, дулаан дамжуулах төв -6ш, Ø150-Ф300 мм шугам-1400 м, Нэвтрэх хонгил-600 м; Ус хангамж: Ø150-300мм шугам-1400 м; Ариутгах татуурга: Ø200-300мм шугам-1000 м, Ø500-543 м; Цахилгаан хангамж: Дэд өртөө-1, РП-1, ХТП-9, 35кВ-ын кабель-28000 м, 10кВ-ын кабель-8000 м; Дулаан хангамж: Ус, дулаан дамжуулах төв-1ш, Ø220 мм шугам-801 м; Ус хангамж: ф150мм шугам-524 м; Ариутгах татуурга: Ø200мм шугам-118 м; Цахилгаан хангамж: ХТП-2 ширхэг, 10кВ-ын кабель 1760 м; Холбоо: 4 яндантай сувагчлал, 640м; Дулаан хангамж: Ус, дулаан дамжуулах төв -1ш, Ø250 мм шугам-8 м; Ус хангамж: Ø100мм шугам-323 м; Ариутгах татуурга: Ø150-250мм шугам-639 м; Цахилгаан хангамж: ХТП-4 ширхэг, 10кВ-ын кабель 2300 м; Холбоо: 4 яндантай сувагчлал, 415м; Дулаан хангамж: Ус дулаан дамжуулах төв-1ш, Ø200мм</p>
4	<p>Баянзүрх дүүргийн 2, 4 дүгээр хороо Мамба дацан хийд орчмын В хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл</p>	<p>Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар</p>	
5	<p>Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хороо, Батлан хамгаалах их сургуулийн орчмын Б хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл</p>	<p>Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар</p>	
6	<p>Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар Орон сууцны ҮII хороолол А хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл</p>	<p>Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар</p>	
7	<p>Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар Орон сууцны ҮII хороолол Ү хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл.</p>	<p>Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар</p>	
8	<p>Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар Орон</p>	<p>Барилга, хот байгуулалтын</p>	

	6 яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар		
<p>Сууцны YII хороолол И хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл</p>		<p>Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар хороо, Орон сууцны YII хороолол Ж, М, Ө, О, П хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл</p>	<p>шугам-60 м; Ус хангамж: Ø100мм шугам-67 м; Ариутгах татуурга: Ø250мм шугам-220 м, Ø200мм шугам-138 м; Цахилгаан хангамж ХТП-4 ширхэг, 10кВ-ын кабель 1200 м; Холбоо: 4 яндантай сувагчлал, 500м; Дулаан хангамж Ус, дулаан дамжуулах төв -20ш, Ø150-Ф400 мм шугам-6700 м; Ус хангамж: Ø150мм шугам-2735 м; Ариутгах татуурга: Ø400мм шугам-230 м; Цахилгаан хангамж: ХТП-8 ширхэг, 10кВ-ын кабель 5000 м; Холбоо: МХТ-3 давхар-1; Хонгилын систем-н=3м, w=2.4м, Урт 1200 м; Үерийн хамгаалалтын байгууламж-2.1 км;</p>
9	Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар		<p>Дулаан хангамж Халаалтын зуух 14.1 Гкал-1 ш, Ус, дулаан дамжуулах төв-2ш, шугам 3780 м; Ариутгах татуурга: Ø150-250мм шугам-371 м; Цахилгаан хангамж ХТП-8 ширхэг; Холбоо: 6 яндантай сувагчлал 1170 м;</p>
10	Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар	<p>Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн мянга орчмын А хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл</p>	<p>Дулаан хангамж Халаалтын зуух 14.1 Гкал-2 ш, Ус, дулаан дамжуулах төв-2ш; Ус хангамж: Ø100-150мм шугам-1139 м; Ариутгах татуурга: Ø150-250мм шугам-801 м; Цахилгаан хангамж РП-1, ХТП-11 ширхэг, 10кВ-ын кабель м; Холбоо: 6 яндантай сувагчлал 1650 м;</p>
11	Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар	<p>Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн мянга орчмын Г хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл</p>	<p>Дулаан хангамж Халаалтын зуух 10.92 Гкал-1 ш, УДДТ-2ш, шугам Ф100-Ф300 Ус хангамж Ф150-200мм шугам-1843 м; Ариутгах татуурга: Ф200-250мм шугам-870 м; Цахилгаан хангамж: РП-2, ХТП-29 ширхэг, 10кВ-ын кабель 22000 м; Холбоо: 6 яндантай сувагчлал 2300 м;</p>
12	Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар	<p>Чингэлтэй дүүргийн 7, 8 дугаар хороо, Монголын МҮОНРТ орчмын А хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл</p>	<p>Дулаан хангамж Халаалтын зуух 1ш-8.25 Гкал/цаг, Ус, дулаан дамжуулах төв-1ш, Ø125-350 мм шугам -735 м, Эх үүсвэрийг барих талаар Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай зөвшилцөх; Ус хангамж Ø150 мм шугам-9 м; Ариутгах татуурга: Ø250мм шугам-312 м; Цахилгаан хангамж ХТП-4 ширхэг, 10 кВ-ын кабель-4500 м;</p>
13	Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар		

14	Баянгол дүүргийн 10, 11, 20 дугаар хороо, Бичил Үл хороолол А хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар	Холбоо: Сувагчлал Ø110 мм-ийн 4-6 яндантай-1095 м; Дулаан хангамж: Халаалтын зуух 1ш-14 Гкал/цаг, Ус, дулаан дамжуулах төв-4ш, Ø125-350 мм шугам-262 м; Ус хангамж: Ø300 мм шугам-951 м; Ариутгах татуурга: Ø400/600мм шугам-2200 м; Цахилгаан хангамж: РП-1ширхэг, ХТП-13 ширхэг; Холбоо: Сувагчлал Ø110 мм-ийн 4-6 яндантай-1776 м; Дулаан хангамж: Халаалтын зуух 2ш-27.61 Гкал/цаг, Ус, дулаан дамжуулах төв-6ш, Ø125-350 мм шугам-2088 м; Ус хангамж: Ø 300 мм шугам-984 м; Ариутгах татуурга: Ø300мм шугам-м; Холбоо: Сувагчлал Ø110 мм-ийн 4-6 яндантай-1830 м; Дулаан хангамж: Ус, дулаан дамжуулах төв-2ш, Ø200-250 мм шугам -750 м Ус хангамж: Ø150мм шугам-50 м; Ариутгах татуурга: Ø200мм-300мм шугам-550 м; Цахилгаан хангамж: РП-1ширхэг, ХТП-10 ширхэг, 10кВ-ын кабель 7000 м; Холбоо: Сувагчлал Ø110 мм-ийн 4-6 яндантай-1500м, МХТ-1, ШК-7500 м; Дулаан хангамж: Төвлөрсөн сүлжээнээс ф-500/400/300 шугам; Ус хангамж: Ø150-250мм шугам-876 м; Ариутгах татуурга: Ø200-3045 м; Цахилгаан хангамж: РП-1 ХТП-630кВа-9 ширхэг, 10кВ-ын кабель 5000 м; Дулаан хангамж: Ус, дулаан дамжуулах төв -5ш, Ø76-325мм шугам 1936 м; Ус хангамж: Ø100мм шугам-313м; Ариутгах татуурга: Ø150-300мм шугам-1143 м, насос станц-1; Цахилгаан хангамж: РП-1 өргөтгөх, ХТП-400кВа-3, 630 кВа-4 ширхэг, 10кВ-ын кабель 5465 м; Холбоо: 2-4 яндантай сувагчлал, шилэн кабель-498 соге-4140м; Дулаан хангамж: Ус, дулаан дамжуулах төв -1ш, Ø377мм шугам 838 м,
15	Баянгол дүүргийн 10, 11, 20 дугаар хороо, Бичил Үл хороолол Б хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл	Барилга, хот байгуулалтын яам/Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар	
16	Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо, Яармаг орчмын талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар	
17	Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 20 дугаар хороо, Цэргийн хотхон орчмын Б хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл	Барилга, хот байгуулалтын яам/Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар	
18	Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 20 дугаар хороо, Цэргийн хотхон орчмын А хэсэгчилсэн талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл	Барилга, хот байгуулалтын яам/ Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газар	
19	Хан-Уул дүүргийн Буянт-Ухаа-2 орон сууцны хорооллын 2 дугаар ээлжийн инженерийн	Барилга, хот байгуулалтын яам/Нийслэлийн гэр хорооллын	

	шугам сүлжээний ажлын төсөл	дэд бүтцийн газар	Ус хангамж: Нөөцийн усан, тоног төхөөрөмж, Ø 300мм шугам-550м;
20	Сонгинохайрхан дүүргийн 30 дугаар хороо, Хилчин хотхон орчмын талбарт баригдах орон сууцны хорооллын дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх төсөл	Барилга, хот байгуулалтын яам/Нийслэлийн тэр хорооллын дэд бүтцийн газар	Дулаан хангамж: Ус, дулаан дамжуулах төв-1ш; 1 дүгээр хэлхээ Ø150-200мм шугам l=250 м; Хонгилын систем автозамын доогуур l=35м/; 2 дугаар хэлхээ Ø50-133 l=2140м.



МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Утас: 31 06 12, 7600 3333-1126, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2022.06.09 № 1/2838

танай 2022.05.25 ны № ХЭГ/1191 -г

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА

Танаас 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн ХЭГ/1191 тоот албан бичгээр ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой асуудлаар тавьсан асуулгатай танилцаж, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 10 хуудастай.

Б.МӨНХБААТАР

152240824

Монгол Улсын Засгийн газрын
Хэрэг эрхлэх газар

Бэлтгэх хөдөлгөөн

2022.6.13

17.00 цаг 40 минут

Барилга, хот байгуулалтын яамны
..06.... дугаар сарын ..09.. -ны өдрийн
01./283.? тоот албан бичгийн хавсралт

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН М.ОЮУНЧИМЭГЭЭС
УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ
АСУУДЛААР ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Асуулга 1: 2020 оноос хойш зогсонги байдалд ороод буй гэр хорооллын дундын бүсүүдэд хэсэгчилсэн дэд бүтцийг холбох болон алслагдсан бүсүүдэд инженерийн дэд бүтэц бий болгох төслүүдийг Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах талаар болон эдгээр төслүүдийн санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна гадаадын зээл тусламжаар шийдэх боломжийн талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөрт гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, газрыг дахин зохион байгуулах төслийг үргэлжлүүлэн, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангах ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд дундын бүсийн гэр хороололд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх дэд бүтцийн төв буюу “Сервис центр”-ийг ашиглалтад оруулах, захын бүсийн гэр хороололд бие даасан эх үүсвэр /сэргээгдэх эрчим хүч, цахилгаан, шингэрүүлсэн болон хийн түлш/ бүхий технологийг нэвтрүүлэх арга хэмжээг тусгасан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 118 дугаар тогтоолоор гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх “Дэд бүтцийн төв”-ийн төсөл хэрэгжүүлэх 16 байршлыг баталсан. “Дэд бүтцийн төв”-ийн төслийн хүрээнд улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт анхны жишиг “Дэд бүтцийн төв” төслийг 100 хувь хэрэгжүүлж дууссан. Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороо “Бичил дэд төв”-ийн 1 дүгээр багц ажил 100 хувь, хоёрдугаар багц ажлын дулааны шугам угсралтын ажлыг энэ онд багтаан хийж дуусгахаар ажиллаж байна. Налайх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Инженерийн дэд бүтцийн төсөл” 75 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороо, Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 23 дугаар хороонд хийгдэх “Дэд бүтцийн төв” төслийн зураг төслийн ажлын гүйцэтгэгчээр “Эм Эс Эл” ХХК ажиллаж байгаа бөгөөд ажлын явц 90 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 179 дүгээр тогтоолоор төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох бололцоогүй гэр хорооллын дундын болон захын бүсийн тодорхой байршлуудад бие даасан болон төвлөрсөн инженерийн дэд бүтэц бүхий нийт 50 бичил дэд төвийг барьж байгуулах төсөл, арга хэмжээг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 2.0 тэрбум юанийн будалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж, шаардагдах санхүүжилтийг 2017-2020 оны улсын төсөвт үе шаттайгаар тусган шийдвэрлэхийг Сангийн сайд, Гадаад харилцааны сайд, Барилга, хот байгуулалтын сайд нарт даалгасан.

Энэ хүрээнд эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан хэлэлцээрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх саналыг 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 03/2343 албан тоотой Сангийн яаманд уламжилж, Сангийн яамнаас мөн өдрийн 10/4156 албан тоотой БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хүргүүлсэн.

БНХАУ-аас МУ-д суугаа ЭСЯ-ны зүгээс дээрх төслийн саналыг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Худалдааны яаманд уламжилсан бөгөөд тухайн үед гуравдагч үнэлгээний байгууллагад шилжүүлсэн байна. БХБЯ-ны зүгээс холбогдох буцалтгүй тусламжийн дагуу “Солилцох захидал” байгуулах хүсэлтээ Сангийн яам болон БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд албан тоотой тус тус илэрхийлсэн болно.

2020 оны 01 дүгээр сард төсөлд хөндлөнгийн дүн шинжилгээ хийх зөвлөх багийг сонгон шалгаруулж одоогийн байдлаар дүн шинжилгээ хийгдэж дуусаагүй байна. 2020 онд гарсан цар тахлаас үүдэн гарсан эдийн засгийн хямралтай холбогдуулан төслийн санхүүгийн хэлэлцээрийг Хятадын тал тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.

2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан Монгол, Хятадын Засгийн газар хоорондын 16 дугаар хуралдаанд тус яамны холбогдох төлөөлөл оролцож энэхүү төслийн хэрэгжилтийг урагшлуулах асуудлаар санал солилцож, Хятадын талаас дэмжиж ажиллахаа илэрхийлсэн. Эл асуудал ЗГХК-ын хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон илтгэх хуудаст тусгаж, баталгаажуулсан.

Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Цай Веньруй-тай 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр барилга, хот байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон уулзалт хийсэн. Эл уулзалтаар тус төслийн хэрэгжилтийг урагшлуулах асуудлаар байр сууриа илэрхийлж, ЭСЯ-ын зүгээс дэмжиж ажиллахаа харилцан илэрхийлсэн.

Асуулга 2: Гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцжуулах ажлын хүрээнд удаашралтай байгаа төслүүдийн гүйцэтгэлийг сайжруулах чиглэлд төлөвлөсөн арга хэмжээнүүдийн талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 07/19, 12/43, 2014 оны 19/23, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 161, 2020 оны 48, 2021 оны 122 дугаар тогтоолуудаар гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийтдээ 28 байршил, 85 хэсэгчилсэн талбай батлагдсан. 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 18 байршлын 56 хэсэгчилсэн талбайд 43 төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 11,755 айлын орон сууцыг ашиглалтад оруулаад байна.

Дээрх 43 төсөл хэрэгжүүлэгчийн ажлын явц өнөөдрийн байдлаар:

- төсөл хэвийн үргэлжилж байгаа-18 төсөл хэрэгжүүлэгч,
- төслийн гүйцэтгэл удааширсан-17 төсөл хэрэгжүүлэгч,
- төслийн ажил дуусаж хүлээлгэн өгсөн-1 төсөл хэрэгжүүлэгч,

- шинээр төсөл хэрэгжүүлэх батламж авсан-16 аж ахуйн нэгж, байгууллага тус тус байна.

Мөн 2015-2021 оны хооронд төслийн явц удаашралтай, гэрээний үүргээ биелүүлээгүй 26 /давхардсан тоогоор/ төсөл хэрэгжүүлэгчийн эрхийг цуцалсан.

Нийслэлийн 2022 оны төсөвт гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажилд 10.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр орчмын "В" хэсэгчилсэн талбайн гадна инженерийн шугам сүлжээний ажил,
- "Туул дэд станц", "Дүнжингарав" дэд станцаас Дэчинравжайлин хийдийн урд тал хүртэл цахилгаан хангамжийн шугам сүлжээний нэвтрэх сувгийн зураг төсөл, барилга угсралтын ажил (БЗД, 13, 14, 26 дугаар хороо),
- Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Орон сууцны 14 хороолол "А" хэсэгчилсэн талбайн цахилгааны 2*1000кВА хүчин чадалтай 5 ком ХТП-ийн зураг төсөл, барилга угсралтын ажил,
- 14 дүгээр хорооллын цахилгааны 110/35/10кв-ын дэд станцын гаргалгаа 4 иж бүрдэл, 10кв-ын хаалттай хуваарилах байгууламж 3 иж бүрдэл, 10кв-ын хаалттай дэд өртөө 12 иж бүрдэл, 10кв-ын 18.4км кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажлын үргэлжлэл,
- 14 дүгээр хороолол, "И" хэсэгчилсэн талбайн гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн дэд бүтцийн гадна цахилгаан хангамж, холбооны шугам сүлжээ (БЗД, 13 дугаар хороо),
- 14 дүгээр хороолол, "И" хэсэгчилсэн талбайн гэр хорооллын дахин төлөвлөлтийн борооны ус зайлуулах шугам сүлжээ (БЗД, 13 дугаар хороо),
- Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр орчмын "В" Хэсэгчилсэн талбайн гадна инженерийн шугам сүлжээний ажил,
- Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах "Түмэн Амгалан" орон сууцны хорооллын гадна инженерийн хангамжийн ажлын үргэлжлэл,
- Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороо гэр хорооллын дахин төлөвлөлтийн Б2 хэсэгчилсэн талбайн нэгдүгээр ээлжийн барилгажилтын төслийн инженерийн шугам сүлжээ,
- Бичил 7 дугаар хороолол орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн "Б" блокын гадна дулаан хангамжийн ажил (БГД, 11, 22 дугаар хороо),
- Сүхбаатар дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Орон сууцны VII хороолол орчмын "Б" хэсэгчилсэн талбайн УДДТ-ийн барилга, тоног төхөөрөмж, гадна дулааны шугамын ажил,
- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн "Эко яармаг-1" хорооллын гадна дулаан хангамж (ХУД, 4 дүгээр хороо).

Асуулга 3: Улаанбаатар хотын гэр хорооллын орчны болон хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн ажлууд, тэдгээрийн санхүүжилтийн хэрхэн шийдсэн талаар:

Орчны болон хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэвтрүүлэх, хүн ихээр зорчдог хотын гудамж талбай, автобусны эцсийн буудлууд дээр нийтийн бие засах газар байгуулах, нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах нийтээр дагах шийдвэр гаргах, хог

хаягдлыг ангилан ялгах үйл ажиллагааг хэвшүүлж, ангилсан хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх, хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийн нөхцөлийг сайжруулж, олон жил хог дарж булсан ландфилын талбайг үе шаттайгаар хэсэгчлэн нөхөн сэргээлт хийх зэрэг ажлууд тусгагдсан.

Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

Шинжлэх Ухааны академийн Газарзүй геоэкологийн хүрээлэнтэй хамтран орчин үеийн судалгааны арга зүй, сансрын өндөр нарийвчлалтай зураг ашиглан нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 144,992 нүхэн жорлон тоологдсон. Нийслэл хотын хөрсний бүтэц онцлогт тулгуурлан нүхэн жорлонгоос үүдэх бохирдлыг 4 төвшинд бүсчлэн гаргасан.

Гандангийн дэнжийн хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр 640 өрхийн нүхэн жорлонд ариутгал халдваргүйтгэл, ашигтай бактери хийх ажлыг зохион байгуулсан. Тус ашигтай бактери /био задлагч/ нь хөрсний бохирдлыг арилгах, шээсний хүчлийг задлах, үнэр дарж, халдваргүйжүүлэхээс гадна хөрсний бордоо болох давуу талтай.

Улсын төсвийн 7,560.0 сая төгрөгийн хөрөнгөөр Туул голын хамгаалалтын бүсэд 4200 айл өрхийн нүхэн жорлонг шинэчлэх ажил хийгдэж байна. 2021 онд 2360 айл өрхийн нүхэн жорлонг шинэчилсэн. 2022 онд үлдсэн айл өрхийн нүхэн жорлонг шинэчилж дуусгана. Мөн улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороонд “Хүн амын эрүүл мэндэд ээлтэй эко ариун цэврийн байгууламж байгуулах” 357 айл өрхийн нүхэн жорлонг шинэчлэх ажлын хүрээнд 160 айлын нүхэн жорлонг бүрэн шинэчилсэн. Уг ажил үргэлжилж байна.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайд нийтийн бие засах газар байгуулах ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо, Драгон төвийн зүүн талд, Хан-Уул дүүргийн ажилчны алдар талбайд тус тус нийтийн бие засах газрыг нийслэлийн төсвийн 215.5 сая төгрөгөөр байгуулсан. Мөн Туул голын эргийн дагуу 6 байршилд эко жорлонг нийслэлийн төсвийн 39.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгуулсан.

Ундны усны эх үүсвэр, ойн сан бүхий газрын орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд усан сан бүхий газар, ундны усны эх үүсвэрийн хориглолт, хязгаарлалтын бүсийн хилд өөрчлөлт оруулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ундны усны нөөц, эх үүсвэрийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах, усны эх үүсвэрүүдэд амьдарч буй гэр хорооллын өрхүүдийн жорлонг доторлуулах, угаадас нүхэн жорлонгийн стандартыг мөрдүүлж, бохир ус татан зайлуулах нэгдсэн системд холбох ажлыг зохион байгуулах, зайлшгүй газар чөлөөлөх шаардлагатай нэгж талбаруудын судалгааг гарган үе шаттай нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөн ажиллаж байна.

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт туул голын хойд эргийн дагуу нэр бүхий 19 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын эзэмшил газрууд нь ойн сан бүхий газрын хамгаалалтын бүс, усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсэд хамаарсан тул газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож нийтийн эдэлбэрт авсан.

Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж Нийслэлийн

Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаандаар хэлэлцүүлэн батлуулсан.

- Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Хөрөнгө гаргах тухай” А/1023 дугаар захирамжаар 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах, нийслэлийн гэр хорооллын айл өрхийн хэрэглээнд зориулан дүүрэг тус бүрт 10,000 тонноос доошгүй сайжруулсан түлшний нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

- 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхийг сайжруулсан түлшний 686 борлуулалтын цэгээр 253,928 тонн сайжруулсан түлшээр хангасан.

- Зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангах ажлын хүрээнд 6,098 өрхөд тус бүр 36 шуудай буюу нийт 219,528 шуудай сайжруулсан түлш олгож ажилласан.

- 2021 оны агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тооллогоор 3-15кВт хүртэл хүчин чадалтай 163,742 зуух, 15-100кВт хүртэл хүчин чадалтай 2,469 зуух, 100-4200кВт хүртэлх хүчин чадалтай 410 усан халаалтын зуух, 4200кВт-аас дээш хүчин чадалтай 41 зуух бүртгэгдсэн байна. Мөн хөдөлгөөнт эх үүсвэр буюу 661,348 авто тээврийн хэрэгсэл тоологдсон байна.

- Түүхий нүүрсний хэрэглээг бууруулах зорилгоор 4 байршлын 36 халаалтын зуухыг буулган, төвлөрсөн дулаанд холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Асуулга 4: 2013 оноос хойш гүйцэтгэл нь удааширсан гэр хорооллын дахин төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлууд, тэдгээрийг түргэвчлэх чиглэлд авч буй арга хэмжээний талаар. Тухайлбал, 2013 онд эхлүүлсэн Чингэлтэй дүүргийн 14, 15 дугаар хорооны 72 дугаар сургуулийн орчим, 2014 онд эхлүүлсэн 9, 10, 11 дүгээр хороо Дэнжийн мянга орчим А хэсэгчилсэн талбай орчмын төслүүд одоо хүртэл ашиглалтад ороогүй байна. Эдгээр ажлуудыг хурдавчилж, төслийг үр дүнтэй гүйцэтгэж дуусгах талаар Барилга, хот байгуулалтын яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар:

Гэр хорооллын дахин төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлууд, тэдгээрийг түргэвчлэх чиглэлд Барилга, хот байгуулалтын яамны зүгээс дараах арга, хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

4.1 Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 8.1.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны зүгээс гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны зохион байгуулалт, оролцогч талуудын эрх зүйн зохицуулалтыг тодорхойлох, төсөл хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх хүрээнд хуулийг дагалдах дараах журам, зааврыг боловсруулж батлуулан мөрдүүлж байна. Үүнд:

- Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 84 дүгээр тушаалаар “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам”;

- Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 122 дугаар тушаалаар “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам” /2021 оны 250 дугаар тушаалаар шинэчлэн баталсан/;

- Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 125 дугаар тушаалаар “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний

үлгэрчилсэн загвар"-ын хүрээнд "Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар", "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар", "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар";

- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 75 дугаар тушаалаар "Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам";

- Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам";

- Засгийн газрын 2018 оны 222 дугаар тогтоолоор "Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам";

- Засгийн газрын 2018 оны 341 дүгээр тогтоолоор "Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах зорилгоор өмчлөгч, эзэмшигч газраар хувь нийлүүлэх журам";

Мөн гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажилтай шууд холбогдох эрх зүйн баримт бичгийн нэг болох Газрын тухай хууль нь 2002 онд батлагдсан бөгөөд 20 жилийн хугацаанд бусад хууль батлагдсантай холбогдуулан нийтдээ 32 удаа нэмэлт, өөрчлөлт орсон нь хуулийн гол зарчим алдагдсан, бусад 60 гаруй хуульд газрын талаарх зохицуулалт, 200 орчим захиргааны хэм хэмжээний актаар газрын харилцааг зохицуулах болсон нь газрын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг бий болгож, иргэд, олон нийтэд ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Энэ хүрээнд тус яамнаас газрын багц хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн бөгөөд УИХ-д өргөн мэдүүлэн батлуулахаар ажиллаж байна. Газрын багц хууль батлагдсанаар дараах ач холбогдол гарна. Үүнд:

- Газрын нэгдсэн төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалттай болно;
- Газар олгох, бүртгэх, гэрчилгээ олгох үйл ажиллагааг цахим системээр ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэйгээр зохион байгуулагдана;
- Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл, боломжийг нэмэгдүүлнэ;
- Төрийн өмчийн газрыг Иргэний хуулийн суурь эрхийн зохицуулалттай нийцүүлэх иргэн, хуулийн этгээдэд тодорхой зориулалт, хугацаагаар шилжүүлэх, гэрээгээр ашиглуулах боломж бүрдэнэ;
- Нийтийн зориулалттай орон сууц болон олон өмчлөгчтэй барилгын доорх газрын эрхийг өмчлөгч нарт нь дундын мэдлийн газрын эрхийг олгох боломж бүрдэнэ;
- Газрын маргаан таслах зөвлөлийг байгуулж газрын маргааны шийдвэрлэх үйл ажиллагааг түргэн, шуурхай болгоно;
- Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх, иргэн хуулийн этгээдэд нөхөх олговор олгох эрх зүйн боломж бүрдэнэ;
- Газрын төлөв байдал чанарт хяналт тавих, газрын ашиглалт, хамгаалалт сайжирна.

4.2 Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн хүрээмжийг нэмэгдүүлэхээр Барилга,

хот байгуулалтын яамны зүгээс БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “Улаанбаатар хотын VII, XIV хорооллын орон сууц VII, МҮОНРТ орчмын хорооллын дэд бүтцийн төсөл”-ийг 2012-2020 онд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд нийт 47 сая ам.долларын санхүүжилтээр Улаанбаатар хотын VII хорооллын гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил, МҮОНРТ орчмын хорооллын гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил болон VII хороолол, МҮОНРТ орчмын хорооллыг цахилгааны эх үүсвэрээр хангах “7 хороолол”, “телевиз” дэд станц, 23,3 км ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг тус тус хэрэгжүүлж дуусгасан.

Мөн Барилга, хот байгуулалтын яамнаас сүүлийн 10 жилийн хугацаанд Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийг эрчимжүүлэх, инженерийн шугам сүлжээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд нийт 621 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 107 төсөл, арга хэмжээг сайдын багцаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн. Үүнээс Баянгол болон Чингэлтэй дүүргийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажилтай холбоотой хэрэгжсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг дараах хүснэгтээр харуулав.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Он		Төсөвт өртөг /сая төгрөг/
1	Гандан хорооллыг орон сууцжуулах, дэд бүтцийг сайжруулах төслийн судалгаа /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/	2012	2012	40
2	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Орон сууцны хороолол төсөл	2010	2019	275,094.50
3	Баянгол дүүрэг, Гандан Орхоны 10 дугаар гудамжны шинэчлэлт, барилгын ажил	2014	2017	381.6
4	Баянгол дүүрэг, Гандан Орхоны 5 дугаар гудамжны дэд бүтцийн ажил	2014	2017	655.8
5	МҮОНРТ орчмын хорооллын 6 хэсгийн 6 ш ус, дулаан дамжуулах төвийн барилга, гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2013	2018	1,633.00
6	Дэнжийн 1000 орчмын инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2017	2018	3,978.40
7	Дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2017	2017	2,334.70
8	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, Орхон хороолол/	2018	2018	1,200.00
9	Гэр хорооллын айл, өрхүүдийн цэвэр, бохир, дулааны шугам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7, 8, 9, 10, 11 дүгээр хороо, Шинэ хороо төсөл/	2019	2019	1,500.00
10	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/	2019	2020	2,000.00
11	"Шинэ хороо" төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7, 8, 9, 10, 11 дүгээр хороо/	2020	2021	7,600.00
12	"Жишиг гудамж" төсөл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9, 10, 11, 21, 22, 23 дугаар хороо/	2021	2022	2,500.00

13	"Жишиг гудамж" төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19 дүгээр хороо/	2021	2022	1,000.00
14	Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, авто замын гэрэлтүүлэг /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2021	2022	400
15	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлийн зураг, төсөв /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, Гандангийн дэнж/	2021	2021	360
16	Инженерийн шугам сүлжээний зураг, төсөв /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2021	2022	800
Нийт				301,478

4.3 Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, иргэдийн орон сууц худалдан авах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

Монголбанк, Засгийн газар хамтран 2013 оноос эхлэн хэрэгжүүлсэн Ипотекийн зээлийн хөтөлбөрт давхардсан тоогоор нийт 110 орчим мянган өрх хамрагдсанаас 22,815 иргэн Улаанбаатар хотод гэр хорооллоос хамрагдаж, 1.2 их наяд төгрөгийн зээлийн санхүүжилтээр анх удаа орон сууц худалдан авсан байна. Энэ нь гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч барилгын компаниудын борлуулалт, төслийн үйл ажиллагааг дэмжиж, иргэдийн орон сууц худалдан авах чадварыг нэмэгдүүлэх нэн чухал ач холбогдолтой арга хэмжээ юм.

Мөн Барилга, хот байгуулалтын яамны зүгээс хүн амын төвлөрлийг сааруулж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэх хүрээнд ипотекийн зээлийг тодорхой зорилтот бүлэгт түлхүү чиглүүлэх, урьдчилгаа төлбөрийн 60 хүртэл хувьд батлан даалт гаргах ажлыг Сангийн яам, Монголбанкттай хамтран ойрын хугацаанд зохион байгуулах чиглэлээр санал бэлтгэн ажиллаж байна.

4.4 Цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ:

Зорилтот бүлгийн иргэдийг орлогод нийцсэн түрээсийн болон түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцаар хангаж, гэр хорооллын дахин төлөвлөлт, газар чөлөөлөлтийн ажлыг эрчимжүүлэх хүрээнд төрийн өмчийн түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас улс, нийслэлийн төсөв, олон улсын хөгжлийн санхүүжилт, төр-хувийн хэвшлийн түншлэлээр "Залуус-1", "Солонго 1, 2", "Баянголын ам", "10,000 айлын эко, ногоон хороолол" гэх мэт орлогод нийцсэн орон сууцны хороолол барих төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төслүүдийг 2028 он хүртэл үе шаттайгаар ашиглалтад оруулснаар нийт 200 гаруй га талбайд 28,000 айлын орон сууц ашиглалтад орж, 100,000 орчим иргэн тав тухтай инженерийн дэд бүтцэд холбогдсон, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэх юм.

Асуулга 5: Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд Чингэлтэй дүүрэгт төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах шаардлагатай 4 хэсэгчилсэн талбай байна. Тухайлбал 2014 оны А/828 дугаар захирамжаар ЧД-ийн 9, 10-р хороо, Дэнжийн мянга орчмын Б хэсэгчилсэн талбай, 2013 оны А/1041 дугаар захирамжаар ЧД-ийн 9, 10-р хороо, Дэнжийн мянга орчмын В хэсэгчилсэн талбай, 2014 оны А/831 дугаар захирамжаар ЧД-ийн 7, 8-р хороо, Баянгол дүүргийн 11-р хороо, МҮОНРТ орчимд, 2014 оны А/962 дугаар захирамжаар ЧД-ийн 7,

8-р хороо, МҮОНРТ орчмын төслүүдэд хэрэгжүүлэгч байгууллагатай маргаан үүсч, үйл ажиллагаа нь гацсан байна. Эдгээрийг эрчимжүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй бусад арга хэмжээний талаар:

Чингэлтэй дүүргийн 13, 15 дугаар хороо, 72 дугаар сургууль орчимд “Асар Өргөө” ХХК, “Буурал сутай” ХХК-иуд Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/538 дугаар захирамжаар төсөл хэрэгжүүлэгчээр батламжлагдсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд “Асар Өргөө” ХХК нь 100 айлыг орон сууцжуулахаар төлөвлөснөөс 2021 онд 20 айлын орон сууцыг ашиглалтад оруулж газар чөлөөлөлт хийсэн 9 нэгж, талбарын өрхүүдийн асуудлыг шийдвэрлэж, орон сууцанд оруулсан. “Буурал сутай” ХХК нь 126 айлыг орон сууцжуулахаар төлөвлөснөөс 48 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан. Газар чөлөөлөлт хийсэн 14 нэгж талбарын айл өрхийг орон сууцанд бүрэн оруулсан. Тус байршилд нийслэлийн 4,501.3 сая төгрөгийн төсвөөр хийгдэж буй инженерийн шугам сүлжээний ажлын хэрэгжилт 75 хувийн гүйцэтгэлтэй байна.

Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн мянга орчим А хэсэгчилсэн талбайд нийслэлийн 7,837.7 сая төгрөгийн төсвөөр хийгдэж буй инженерийн шугам сүлжээний ажлын хэрэгжилт 89 хувьтай байна. Тухайн хэсэгчилсэн талбайд Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/466 дугаар захирамжаар “Бармон” ХХК төсөл хэрэгжүүлдэг бөгөөд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөөр 3,741 айлыг орон сууцжуулахаар төлөвлөснөөс 2019 онд 234 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, газраа чөлөөлсөн 106 нэгж талбарын өрхийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. 2022 онд 234 айлын орон сууцыг ашиглалтад оруулахаар төлөвлөн, төслийн ажил хэвийн явагдаж байна.

Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 орчмын “Б”, Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 орчмын “В”, Чингэлтэй дүүргийн 7, 8 дугаар хороо МҮОНРТ орчмын талбайн нэгж талбарыг жижиглэн хувааж, дахин сонгон шалгаруулалт явуулахаар ажлын даалгаврыг шинэчлэх ажил хийгдэж байна.

Чингэлтэй дүүргийн 7, 8 дугаар хороо, Баянгол дүүргийн 11 дүгээр хороо МҮОНРТ орчим болон Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 орчмын талбайд төсөл хэрэгжүүлэгч “Эрэл” ХХК-ийн эрхийг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/268, А/269 дүгээр захирамжаар цуцалсан бөгөөд одоогоор шүүхийн маргаантай байна. Шүүхийн маргаан эцэслэгдэн шийдвэрлэгдсэний дараа сонгон шалгаруулалтыг зарлахаар төлөвлөсөн.

Чингэлтэй дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 орчмын “В” хэсэгчилсэн талбайд 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр төсөл сонгон шалгаруулалт зарлаж, “Рино инженеринг” ХХК нь үнэлгээний хорооны дүгнэлтээр төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан боловч тус байршилд Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр болон Чингэлтэй дүүргийн 8, 9 дүгээр хороодын нутаг дэвсгэрт дамнан байрших цэвэр усны хамгаалалтын бүс байгуулагдахаар төлөвлөсөн байсан тул тухайн компани төсөл хэрэгжүүлэх ажлыг явуулахаас татгалзсан. Иймд төлөвлөгдсөн газруудыг байршлаас хасаж, хэсэгчилсэн талбайд дахин ерөнхий төлөвлөгөө батлуулахаар ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/962 захирамжаар Чингэлтэй 7, 8 дугаар хороо, МҮОНРТ орчмын талбайд “Басмаа” ХХК шалгарсан боловч 2018 оны А/434 дугаар захирамжаар төслийг цуцалсан. Тус компаниас үүсгэсэн шүүхийн маргаан шийдвэрлэгдсэн тул төсөл хэрэгжүүлэгчийг дахин сонгон шалгаруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Нийслэлийн зүгээс 2025 он гэхэд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслөөр нийт 20,000 айлын орон сууцыг ашиглалтад оруулах зорилт тавин ажиллаж байгаа болно.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ